*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БАЯРМАГНАЙН МӨНХ-АМАРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | | |
| 1 | Байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр | Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар | 1. Байгууллагын үйл ажиллагаа болон гаалийн холбогдолтой хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, ажлыг зохион байгуулж, тайлант хугацаанд www.customs.gov.mn сайтад нийт 108 мэдээ нийтлэгдсэн байна. "Монголын гааль" 'пэйжид 179 мэдээлэл оруулсан байна.<br>2. Гаалийн байгууллагын талаар цахим орчин, хэвлэл мэдээллийн | 1.Байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж, нийт түгээсэн мэдээ мэдээллийн тоо суурь түвшнээс өссөн байна.<br>2.Гаалийн байгууллагын талаар цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй ташаа мэдээлэл, | 1. Монголын гааль фэйсбүүк пэйж энэ оны эхний хагас жилд 24 мянган дагагчтай байсан бол сүүлийн хагас жилд 27 мянган дагагчтай болсон. 2023 онд 21.1 мянган дагагчтай байсан бол 2024 оны 12 сарын 08-ны байдлаар 27 мянган дагагчтай болж өмнөх оноос 28% өссөн байна. Монголын гааль пэйжид өмнөх онд 312 пост мэдээлэл нийтэлсэн бол энэ онд 409 пост мэдээллийг түгээсэн нь өмнөх оноос 97-оор буюу 31%-аар өссөн байна. Тайлант хугацаанд Монголын гааль фэйсбүүк пэйжид 409 мэдээ, мэдээллийн 91 видео, 38 рийл, 125 фото зурган, 148 постер мэдээ, мэдээлэл нийтэлсэн байна. Шинээр 3 лайв, 4 линкэн мэдээ оруулсан. Мөн https://www.customs.gov.mn/ вэб хуудсанд өмнөх онд 188 мэдээ, мэдээлэл нийтэлсэн бол энэ онд 283 мэдээ, мэдээллийг нийтэлж өмнөх оноос 95-аар буюу 103,4% өссөн. 283 мэдээлэлд 180 мэдээ, 103 постер мэдээлэл орсон нь байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан байна. Мөн мэдээ мэдээллийн сайтуудаар 311 мэдээ, өдөр тутмын сониноор 45 мэдээ, телевизийн 230 мэдээ, радиогоор 63 мэдээлэл түгээсэн байна. | 2024.01.01 - 2024.12.10 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангаж ажилласан байдал | | хэрэгслээр түгээгдэж буй ташаа мэдээлэл, нийгмийн үнэлэмжийг бууруулах сөрөг мэдээллүүдэд удирдлагуудаас өгсөн чиглэлийн дагуу 2 удаа хэвлэлийн бага хурал хийж хариу арга хэмжээг авсан.<br>3. Энх-Арслан ХХК 2024 оны 3 дугаар сараас эхлэн сар бүр хэвлэлийн мониторингийн тайланг СХОГ-т хүргүүлж байсан. Гаалийн байгууллагын талаар цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй мэдээлэлд дүн шинжилгээ хийх зорилгоор Энх-Арслан ХХК-тай хамтран ажиллаж “ГЕГ” болон салбарын бусад түлхүүр үгтэй холбоотой мэдээллийг ажлын өдрүүдэд, өдөр бүр 4 удаагийн давтамжтай шүүлт хийн тухай бүр "Гаалийн хэвлэлийн тойм" вайбер группд | нийгмийн үнэлэмжийг бууруулах сөрөг мэдээллүүдэд удирдлагуудаас өгсөн чиглэлийн дагуу хариу арга хэмжээг авна.<br>3.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ. Удирдлагыг тухай бүрд нь мэдээллээр хангаж ажилласан байна. | 2. Удирдлагыг өдөр бүр мэдээллээр хангаж чиглэл авч ажилласан. Үүний үр дүнд Энэ онд гарсан сөрөг мэдээллийг залруулж олон нийтэд зөв, эерэг мэдээлэл өгөх зорилгоор 4 удаагийн хэвлэлийн бага хурал, нээлттэй хаалганы 4 удаагийн өдөрлөгийг /УХШИГГ, УБГГ, ЗҮГГ, ЧХОУНБГГ/ хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтэд нээлттэй зарлаж зохион байгуулсан нь өмнөх оноос 0,6%-аар өсжээ.<br>Эдгээр сөрөг мэдээлэлд хариу өгөх бүрд гаалийн байгууллага болон бусад төрийн байгууллагын хариуцсан чиг үүргийн талаарх мэдээллийг өгч ажилласан. Үүнд:<br>- Гаалийн Ерөнхий газраас “Том тэрэгний дугуйнд чоно нууж хилээр гарсан зөрчилд Хятадын талаас мэдээлэл авч, хяналт шалгалт явуулна” гэх мэдээлэл. 2024.01.12<br>- Эрээний хилээр 30 кг-аас дээш ачаатай хүнийг нэвтрүүлэхгүй гэх мэдээлэлд 2024.01.16<br>- Гаалийн байгууллага иргэдийг чирэгдүүлж татвараа дур зоргоороо нэмж, хүчээр төлүүлж буй асуудалд тайлбар хийсэн 2024.02.05<br>- Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн дарга Ч.Чимгэрэл хүчээр татвар төлүүлсэн тухайд тайлбар, мэдээлэл өгсөн 2024.02.05<br>- ГЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга Ч.Тамираа: Гомдол гаргасан иргэний тухай тайлбар мэдээлэл 2024.02.05<br>- ГЕГ-ын Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга Э.Лхагвасүрэн гомдол гаргасан иргэний тухай 2024.02.05<br>- ГЕГ-ын Дотоод хяналт, шалгалтын хэлтсээс витаминтай холбоотой асуудлыг шалгаж байгаа тухай тайлбар, мэдээлэл өгсөн 2024.02.25<br>- Ч.Тамираа: Гаалийн ажилтан ачаанд шалгалт хийхдээ хувьдаа завшиж, өөрөө ууж хэрэглээгүй нь камерын бичлэгээр тогтоогдсон 2024.02.26<br>- ГЕГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга Б.Мөнх-Амар “Контейнер юань”-н тухай мэдээлэлд livetv.mn сайтад тайлбар, мэдээлэл өгсөн 2024.03.26<br>- Архины болон хүнсний аюулгүй байдлын шинжилгээний талаар Гаалийн төв лабораторийн дарга С.Цэрэнчимэд хэвлэлүүдэд тайлбар мэдээлэл өгсөн. 2024.04.03 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тавигдаж гаалийн байгууллагын удирдлагуудад шууд танилцуулж байсан. Удирдлагыг өдөр бүр мэдээллээр хангаж ажилласан байна. | | - ГЕГ ДЭД ДАРГА ЭНХТАЙВАН- Ногоон автобус хилээр орж ирэхэд техникийн мэргэжлийн хүн байгаагүй. Маргаашийн сонсголд оролцох талаар 2024.05.21<br>- ГЕГ-аас 19 мянган төгрөгөөр бродюр оруулж ирсэн гэх асуудалд тайлбар мэдээлэл өгөв. 2024.10.04<br>- Улаанбаатар хотын Гаалийн байцаагчид үндэслэлгүй хөрөнгөжсөн гэх асуудалд ГЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга Ч.Тамираа хэвлэлүүдэд тайлбар, мэдээлэл өгөв. 2024.11.22<br>- Иргэн Т.Нэргүй Гаалийн ерөнхий газар болон Замын-Үүд боомтоос лайв хийж нэр бүхий байцаагч болон гаалийн байгууллагын үйл ажиллагааны тухай гомдол гаргасан явдалд Олон нийттэй харилцах албаны дарга Б.Мөнх-Амараар ахлуулсан ажлын хэсэг Замын-Үүд боомтод очиж ажиллан үйл ажиллагаатай нь танилцан мэдээлэл бэлтгэж ажилласан. 2024.11.25<br>3. Энх-Арслан ХХК-тай Медиа мониторингийн үйлчилгээг авах байдлаар хамтран Монгол улсад идэвхтэй 200 гаруй мэдээллийн сайтаас “ГЕГ” болон салбарын бусад түлхүүр үгтэй холбоотой нийтлэлийн мониторингийн тайланг сар бүр хийж байна. Хэвлэлээр гарсан мэдээллүүдэд 7 хоног бүр мониторинг хийж ажилласан.<br>Гаалийн байгууллагын талаар цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй мэдээллийг ажлын өдрүүдэд, өдөр бүр 4 удаагийн давтамжтай шүүлт хийн тухай бүрд нь "Гаалийн хэвлэлийн тойм" вайбер группд байх ЗББДБ-ын 33 дарга удирдлагад шууд танилцуулж, тухай бүрд нь чиглэл авч ажилласан. Эдгээр мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд өмнөх онд гаалийн байгууллагатай холбоотой нийт 1539 мэдээ, мэдээлэл илэрсний 201 мэдээ нь ОНХА-аас бэлтгэн түгээсэн гаалийн эх сурвалжтай мэдээ байсан бол 2024 онд 3029 мэдээлэл илэрснээс 409 мэдээ нь ОНХА-аас бэлтгэсэн гаалийн эх сурвалжтай мэдээ байв. Энэ нь гаалийн эх сурвалжтай мэдээ, мэдээлэл олон нийтэд хүрэх байдал өмнөх оноос 103.4 хувиар өссөн үзүүлэлтийг харуулж байна. Мөн УХШИГГ, ЧХОУНБГГ, УБГГ, ЦБТ, СЭГГ, ДАГГ-газруудад уулзалт, сургалт хийсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран мэдээлэл солилцох, байгууллагыг төлөөлөн хамтран ажиллах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байдал | Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар | 1. Телевизийн 20 гаруй байгууллагатай байнгын хамтын ажиллагаатай ажилладаг, мэдээлэл авах хүсэлтийг нээлттэй хүлээн авч, ажиллаж байна.<br>2. Чиг үүрэг хариуцсан ЗББНДБ, харьяа газар, хороодтой хамтран олон нийтэд түгээх шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр боловсруулан ажиллана.<br>3. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна. | 1.Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нээлттэй хамтран ажиллаж, байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангасан байна.<br>2. Чиг үүрэг хариуцсан ЗББНДБ, харьяа газар, хороодтой хамтран олон нийтэд түгээх шаардлагатай мэдээ, мэдээллийн төлөвлөөг авч нэгтгэн, шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр боловсруулан ажиллана.<br>3.Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх 2 удаагийн сургалтаар 160 албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч | 1. ОНХА телевизийн 20 гаруй байгууллага, 30 гаруй сайт, өдөр тутмын 3 сонины сэтгүүлчидтэй байнгын хамтын ажиллагаатай ажилладаг бөгөөд мэдээлэл авах хүсэлтийг нээлттэй хүлээн авч, ажиллаж байна. Тайлант хугацаанд Гадаад худалдааны статистик мэдээллийг Bloomberg TV -тэй тогтмол хамтран ажиллаж түгээв. Мөн MNB TV, Eagle TV , C-1, central tv, тэнгэр ТВ, NTV, TV-9, TV-5 зэрэг телевизүүдээр, ikon.mn, isee.mn, medee.mn, mnb.mn, Mnews.mn, montsame.mn, murch.mn, arslan.mn, ubn.mn, unuudur.mn, mass.mn зэрэг мэдээний сайтууд албанаас гаргасан мэдээг түгээн ажиллаж байна. Мөн ОНХА-наас Фэйсбүүкээр дамжуулан 239 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”, 148 гишүүнтэй “Сэтгүүлч”, 246 гишүүнтэй “Хэвлэлийн төлөөлөгч”, 88 гишүүнтэй “Гаалийн мэдээ, мэдээлэл”, 250 гишүүнтэй “Хэвлэлийн бага хурал”, вайберийн 44 гишүүнтэй “Гаалийн хэвлэлийн тойм”, 248 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”гэх мэт хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн группт мэдээ, мэдээллийг ашиглаж болох байдлаар түгээн ажилласан. Хэвлэл мэдээллийн байгууллагатай мэдээлэл солилцох, байгууллагыг төлөөлөн ажиллахтай холбоотой харилцаанд гомдол гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч байхгүй. 8 удаа сөрөг мэдээлэлд хариу тайлбар мэдээллийг өгч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдээс ирсэн 70 гаруй хүсэлтийг албаны болон албан хаагчдын хувийн утас, фэйсбүүк чат болон Viber, бусад сувгаар нээлттэй байдлаар хүлээн авч шийдвэрлэсний үр дүнд гаалийн байгууллагын нээлттэй ил тод байдлын талаар гомдол гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч гараагүй байна. Утсаар хүлээн авч байгаа хүсэлтийг дэвтэр нээн бүртгэж байгаа болно.<br>ОНХА-аас бэлтгэн боловсруулсан 409 мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн группүүд рүү түгээж ажилласан. Мөн телевизээр цацагдсан мэдээ мэдээллийн тоо 230, мэдээллийн сайтаар гарсан мэдээллийн тоо 311, сонинд нийтлэгдсэн мэдээний тоо 45 байна. | 2024.01.01 - 2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сургалтыг зохион байгуулсан байна. | 2. Чиг үүрэг хариуцсан ЗББНДБ-дад 2024/06 дотоод зурвасаар 104 санал авч, харьяа гаалийн газар, хороодтой хамтран ажиллах саналыг 2024.01.25-ны өдрийн 01-1/324 албан бичгээр өгч, 207 гаруй саналыг хүлээн авч нэгтгэсэн.<br>Энэхүү авсан саналыг байгууллагын удирдлагад танилцуулж өгсөн чиглэлийн дагуу мэдээлэл бэлтгэх төлөвлөгөө гарган ажилласан. 1-р улирлын төлөвлөгөөт саналаас шаардлагатай 28 ажил, 2-р улиралд 25 ажил, 3-р улиралд 26 ажил, 4-р улиралд 30 ажлыг тус тус удирдлагаас чиглэл аван баталгаажуулж, 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, мэдээ мэдээллийг түгээсэн.<br>СЭГГ, ЗҮГГ-т томилолтоор ажиллаж Үүрэг хүлээсэн гаальчин нэвтрүүлгийн 2 дугаар, тус гаалийн газрын үйл ажиллагааг сурталчилсан 7 мэдээ мэдээллийг боловсруулан түгээж ажиллав.<br>3. ОНХА чиг үүрэг хариуцсан нэгжүүдтэй хамтран ажиллаж хэвлэлийн бага хурал, нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслээр яриа өгөх албан хаагчдад зориулсан төлөвлөгөөт болон цаг үеийн сургалтуудыг амжилттай зохион байгуулсан.<br>Үүнд:<br>- 2024.02.26-ны өдөр ГЕГ-ын ЗББНДБ-ын албан хаагчдад зориулсан сургалтад 23 албан хаагч оролцсон.<br>- 2024.03.21-ны өдөр УХШИГГ албан хаагчдад зориулсан сургалтад 60 хүн оролцсон.<br>- 2024.03.23-ны өдөр СЭГГ-т томилолтоор ажиллахдаа 50 албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан.<br>- 2024.04.30-ны өдөр ЧХОУНБГГ-ын албан хаагчдад зориулсан сургалтад 118 хүн оролцсон.<br>- 2024.05.11-ны өдөр УБГГ-ын албан хаагчдад зориулсан сургалтад 140 хүн оролцсон.<br>- 2024.06.04-ны өдөр ЦБТ-н албан хаагчдад зориулсан сургалтад 50 хүн оролцсон.<br>- 2024.06.06-ны өдөр СЭГГ албан хаагчдад зориулсан сургалтад 76 хүн оролцсон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - 2024.06.07-ны өдөр ДАГГ албан хаагчдад зориулсан сургалтад 25 хүн оролцсон.<br>Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх 8 удаагийн сургалтаар 542 албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулсан. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал сургалтын тоо 4 дахин өссөн байна. Мөн видео яриа, рийлийн бичлэг хийлгэж байгаа алба хаагчдын 80 хувьд дадлага хийж суралцах боломжийг олгож, тус бүр 2-3 бичлэг хийлгэх ганцаарчилсан сургалтад хамруулсан нь энэ оны видео контентоор хүргэх мэдээллийн тоо өсөхөд голлон нөлөөлсөн. | | |
| 3 | Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэх | Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар | 1. Байгууллагын албан ёсны цахим хуудсыг тогтмол хөгжүүлж, өөрийн байгууллагад хамаарах хуулиар хаалттай, хязгаарлалтай гэж тогтоосноос бусад мэдээллийг нээлттэй ил тод байлгаж, 2023 оны мэдээллийг А дүнтэй үнэлүүлэв.<br>2. Гаалийн байгууллагад холбогдолгүй 13 мэдээллийг тус жагсаалтаас хасуулж, үлдсэн 85 мэдээллийг 100% байршуулж Цахим хөгжлийн яаманд тайлагнав. Байгууллагад хамаарах, хуулиар хаалттай, | 1.Байгууллагын цахим хуудсыг тогтмол хөтөлж хөгжүүлж, Цахим хөгжлийн яаманд 2023 оны ажлаа 95 хувиас дээш “А” үнэлгээтэй дүгнүүлнэ.<br>2.Байгууллагад хамаарах, хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ЗББНДБ-уудаас авч тухай бүр нь үнэн зөв, ил тод байршуулна.<br>3.Харьяа гаалийн газар, хороодын цахим хуудасны шинэчлэл 60 хувиас дээш хийгдсэн байна. | 1. Гаалийн байгууллагын веб сайтад Нийтийн мэдээллийн ил байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг гаалийн байгууллагын www.customs.gov.mn вэб сайтын үндсэн болон дэд цэсэд тогтмол шинэчлэн байршуулж, байнга ил тод нээлттэй байлгах мэдээллүүдийн шилэн индексийн тайланг 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Цахим хөгжлийн яамны Shilen.gov.mn сайтад үнэлүүлэхээр илгээсэн байгаа. Бүх төрийн байгууллага, яам агентлаг үнэлгээг хийдэг учраас хариу 2024 оны 12 сард гарна.<br>2. Тайлант хугацаанд customs.gov.mn сайтын мэдээллийн мэдээ, мэдээллийг шинэчлэх чиглэлээр ОНХА-аас ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудад чиг үүргийн дагуу мэдээллээ шинэчилж ирүүлэх чиглэлийг 11 дотоод зурвасаар хүргүүлж, тус сайтын цэс бүрийн мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулсан.<br>Төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай байлгах хүрээнд үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдал, авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр 46 мэдээллийн байршуулсан байна. 2024 оны “Төсвийн гүйцэтгэл”-ийг сар бүр тогтмол 6 удаа, “Худалдан авах ажиллагаа”-ны тендерийн урилгыг 8 удаа зарласан хугацаанд байршуулсан.<br>3. Харьяа гаалийн газар, хороодын цахим хуудасны шинэчлэлийг сайжруулахаар Мэдээллийн технологийн газартай хамтран ажиллаж байна. 2024 онд Харьяа гаалийн | 2024.01.01 - 2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ЗББНДБ-уудаас авч тухай бүр нь үнэн зөв, ил тод байршуулна.<br>3. Харьяа гаалийн газар, хороодын цахим хуудасны шинэчлэлийг 3-4 улиралд хийхээр төлөвлөсөн байна. | | газар, хороодын админуудад мэдээлэл оруулах, вэб сайт дээр хэрхэн ажиллах талаар цахим сургалт хийсэн. Тайлант хугацаанд customs.gov.mn сайтын мэдээллийн мэдээ, мэдээллийг шинэчлэх чиглэлээр Олон нийттэй харилцах албанаас "манай байгууллагын customs.gov.mn сайтын зарим цэсийг шинэчлэх, зарим ажиллахгүй байгаа цэсийг ажиллагаанд оруулах"-ыг МТГ-т Дотоод зурвас илгээж хамтарч ажилласнаар, Харьяа гаалийн газар, хороодын цахим хуудасны шинэчлэл 90 хувиас дээш хийгдсэн байна. 19 газар хороодын веб сайтын шинэчлэлт бэлэн болж, ажиллаж байгаа. Төлөвлөснөөс 25% илүү байна.<br>МУ-ын ЗГ-ын 2024.09.04-ний өдрийн хуралдаанаар “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг ашиглах журам” гарсан бөгөөд төрийн байгууллагуудын цахим хуудас gov.mn гэсэн нэг загвар, стандарттай болж байгаа тул нэгдсэн нэг сайтад ГЕГ-ын 2023, 2024 оны мэдээллийн баазыг сайт руу байршуулах ажил хийгдэж байна. https://mddc.gov.mn/mn/2024/12/20300/?fbclid=IwY2xjawG_vCRleHRuA2FlbQIxMAABHfUjugd0aAqPSlKoyS5pKIq4dxfoJPPQlKwPOYfJep-MpVQWXFjqFpbBuw_aem_K8ZyLU8w7I4zA-VyFCM-tA | | |
| 4 | Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой видео танилцуулга, хэвлэлийн эх бэлтгэсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 39 бичлэг, видео, 64 постер, 76 зураг мэдээ, мэдээлэл бэлтгэн, удирдлагуудад танилцуулан нийтэд хүргэсэн байна. | Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бичлэг, видео, постер, зураг бэлтгэн, удирдлагуудад танилцуулан нийтэд хүргэсэн байна. | 2023 онд гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 312 бичлэг, видео, постер, зураг мэдээ, мэдээлэл бэлтгэн боловсруулж, удирдлагад танилцуулан түгээсэн бол 2024 онд энэ тоо 409 болж өмнөх оноос 97-оор буюу 31%-иар өссөн байна. Тайлант хугацаанд гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 91 бичлэг, видео, 148 постер, 125 зураг орсон байна. Мөн баяр наадам, хурал зөвлөгөөн, бусад арга хэмжээнд зориулж 24 баннер, урилга, зурагт хуудас бэлтгэсэн нь өмнөх оноос 12%-иар өссөн байна. Мөн зураглаач эвлүүлэгчээр ажиллаж байгаа албан хаагчдаа бие даан сурах боломжоор хангаж мэдээлэл түгээх шинэ төрөл болох лайв, рийлийн бичлэг хийх ажлыг туршиж эхэлсэн. Энэ онд 3 лайв бичлэг хийж, 4 линкээр судалгаа авч, 38 рийл мэдээ, мэдээлэл бэлтгэн удирдлагуудад танилцуулан нийтэд хүргэсэн нь Монголын гааль пэйж хуудасны дагагчийн тоо өмнөх оноос 28% өсөхөд голлон нөлөөлсөн бөгөөд 12-р сарын 08-ны байдлаар | 2024.01.01 - 2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | рийл бичлэгийн үзэлт буюу хандалт өдөрт дунджаар 212 мянга болж нэмэгдсэн байна. | | |
| 5 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Олон нийттэй харилцах албаны үйл ажиллагаанд хамааралтай бодлогын баримт бичгүүд байгаагүй болно. | Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой үүрэг даалгавар энэ онд ОНХА-нд өгөөгүй болно.<br>2024 оны эхний хагас жилд өгсөн ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу дараах ажлыг гүйцэтгэлээ.<br>Сангийн яамны 2024 оны шуурхай хуралдаанаас гаалийн байгууллагад өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг цаг хугацааны хоцрогдолгүй 100 хувь биелүүлэн ЗУГ-т цаг хугацаанд өгч ажилласан.<br>Бодлогын бичиг баримтад хамаарах өөрт хамаарах жагсаалтыг гарган, биелэлтийг тухай бүр ЗУГ-т хүргүүлэн ажиллаж байна. | 2024.01.01<br>-<br>2024.12.10 | 100 |
| 6 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Олон нийттэй харилцах албаны холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан. | Олон нийттэй харилцах албаны холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан талаар тайлагнана. | ОНХА нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж Гаалийн байгууллагын олон нийтэд нээлттэй байх зорилтыг хангаж ажилладаг.<br>1.Гаалийн хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын үйл ажиллагааг гаалийн харилцаанд оролцогчид, олон нийтэд хүргэх зорилгоор 409 мэдээ, мэдээллийг customs.gov.mn цахим хуудас, Монголын гааль пэйж хуудсанд байршуулсан.<br>2. Тус хэлтсийн чиг үүргийн хэмжээний нийт 6 үйл ажиллагаа, арга хэмжээ, хөтөлбөрийн тайлангийн биелэлтийг хугацаанд нь тайлагнав.<br>- “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан хүргүүлэх тухай“ монгол улсын сангийн сайдын 2024 оны 03/1172 албан бичгээр өгсөн зөвлөмжийн тайлан<br>- Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт<br>- “Гаалийн байгууллагын шударга байдлын үнэлгээг 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлт<br>- Гаалийн байгууллагын 2024 оны хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт<br>- Гаалийн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 2024.01.01<br>-<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Гаалийн байгууллагын 2024 оны жилийн үйл ажиллагааны ил тод байдлын тайлан<br>3.customs.gov.mn цахим хуудасны Эрх зүй буланд 1 олон улсын гэрээ, гаалийн багц хуулиуд байршуулсан байна.<br>4. 5 хууль, журам, 2 зааварт санал авахаар customs.gov.mn цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулсан.<br>5. “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас shilen.gov.mn сайтын 2.0 хувилбарт мэдээллээ илгээж 2 удаа тайланг хүргүүлсэн.<br>6. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд ГЕГ-ын хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр эцэг, эхийн зөвлөлийн гишүүдийн багт ГУАБ Б.Сайханзаяа орж ажиллан 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан.<br>7. Гаалийн тухай хуулийн 4-р бүлэг, Гаалийн тухай хуулийн 5.2 зүйл, Гаалийн тариф, татварын тухай хуулийн 21.2, 22.1 заалтуудыг үндэслэн Гаалийн байгууллагын нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргасан.<br>8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд Гаалийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бүрдүүлэн дохионы хэлний хэлмэрчтэй видео контент бэлтгэсэн.<br>9. Харааны бэрхшээлтэй иргэд улсын хилээр нэвтрэхэд Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журмыг брааль дээр хэвлүүлсэн.<br>10. ХАСХОМ-ыг 2024 оны тайланг хуулийн хугацаанд 7 албан хаагч холбогдох баталгааны маягтын дагуу гарган ХНХ-д хүлээлгэн өгч, 100 хувь баталгаажуулсан. ХАСУМ-ийг шилжин ажиллах нэг албан хаагч мэдүүлж, хуулийн хугацаанд нь баталгаажуулсан.<br>11. ДГБ-ын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Гаалийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, ЗГ-аас хэрэгжүүлж байгаа цахимжилт, "Шүүр", "Шүгэл" ажиллагаа, авлигатай тэмцэх хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, аяны хүрээнд 11 төрлийн "Авлигын эсрэг нэгдье, Үгүй гэж хэлээд өөрчилье" уриатай соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг Гаалийн байгууллагын албан ёсны хуудас “Монголын гааль” фэйсбүүк пэйж хуудаснаас түгээж, олон нийтэд сурталчилсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | АТГ-тай хамтран гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 3 минутын видео шторкийг бэлтгэсэн. Контентыг гаалийн байгууллагын “Монголын гааль” пэйж хуудас, “Монголын гааль” твиттер, customs.gov.mn вэб хуудас, youtube хуудсанд байршуулан гадаад худалдаа эрхлэгч, иргэд болон олон нийтэд түгээсэн.<br>12. "ГЕГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэдээллийг эрчимжүүлж холбогдох хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор "Гаалийн шинэчлэл-Үр дүн 2024" зорилтот контентуудыг үе шаттай бэлтгэн түгээх ажлыг зохион байгуулав. | | |
| 7 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Шинээр 2024 онд нэмэгдсэн шалгуур үзүүлэлт тул 2023 онд төлөвлөгөөгүй. | Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэнэ. | Олон нийттэй харилцах албаны чиг үүрэг, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг давхардалгүй, орхигдуулахгүй, үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор тус албаны дотоод эрсдэлийн санг үүсгэн 6 албан хаагчаас ганцаарчилсан болон фокус ярилцлага авах байдлаар судалгаа авч, тус судалгаанд үндэслэн эрсдэлийн санг үүсгэв.<br>1. Гаалийн байгууллагын нэр хүнд, олон нийтэд цацагдаж буй мэдээ мэдээлэлд мониторинг хийж болзошгүй эрсдэлийг тооцон удирдлагад тухай бүр нь танилцуулж энэ онд 14 удаагийн хариу арга хэмжээг зохион байгуулж шаардлагатай тохиолдолд тайлбар мэдээллийг түгээж ажиллав.<br>2. Олон нийттэй харилцах албаны 6 албан хаагч ГЕГ--ын ЭУХ-ээс танхимаар, ДХАБХ-ээс цахимаар сургалт авч эрсдэлийн санд дүн шинжилгээ хийх, эрсдэл бууруулах арга хэмжээг хэрхэн зохион байгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажиллав. "ОНХА-ны эрсдэлийн сан"-гаас бууруулсан эрсдэлийг санд бүртгэж, үр дүнг тайлагнав. Үүнд:<br>- Албан хаагчдын интернэтийн хурд хангалтгүйгээс шалтгаалж байсан (2 ярилцлага видео мэдээлэл татах хурд 4 цаг орчим байсныг МТТ-тэй хамтран 20 мин орчим болгож бууруулсан) эрсдэлийг энэ оны 9 сард шийдвэрлэн ажлын бүтээмжийг 12 дахин нэмэгдүүлэв.<br>- Дизайнерын компьютерыг шинэчлэх хүсэлтийг СХОГ өгснөөс хойш 4 жилийн дараа шийдвэрлэгдэв. | 2024.01.01<br>-<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Видео камер, микрафон, камер тэнцвэржүүлэгч хөл зэрэг орчин үеийн тоног төхөөрөмж, албан хаагчдад ажлын шаардлага хангасан хүчин чадал бүхий компьютер шийдвэрлэж өгөх хүсэлтийг ХОГ өгснөөс хойш 4 жилийн дараа шийдвэрлэгдэв.<br>- Хүний нөөцийн хувьд дутуу буюу нэг албан хаагчид оногдох ачаалал өндөр байсныг ХНХ-ийн хэлтэстэй хамтран шийдвэрлэх арга хэмжээ авч, нэг орон тоонд тусгай шалгалт зарлаж, албаны дарга томилогдов.<br>Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэв. Түүнд дүн шинжилгээ хийж 2024 онд нэгжийн эрсдэлийг 30.7 хувь бууруулав. | | |
| 8 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн "Цахим бүрдүүлэлтийн нэгдсэн үйл ажиллагаа"-ны Сурталчлан таниулах дэд ажлын хэсэг байгуулсан.<br>Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд 1 видео шторк 2 ярилцлага, 2 постер мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэн ажиллаж байна. Эдгээр мэдээллийг<br>Монголын гааль пэйж хуудасны 15 мянган дагагчтай пэйж хуудаснаас дунджаар 222 мянган хүн шууд, 63,0 мянган хүн шууд бусаар хүлээн авч байна | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан талаар тайлагнана. | 1. ЗДАСП-т 6 үүрэг даалгавар, 2 зөвлөмж өгснийг хугацаанд нь биелэлтийг оруулсан.<br>2. 2024 оны байдлаар албаны жилийн биелэлтийг тухайн цаг хугацаанд нь хүргүүлсэн.<br>3. ГЕГ-ын ЗББДБ-ууд, гаалийн газар хороодоос 243 албан тоот дотоод зурвас ирснийг хугацаанд нь хариуг өгч, шийдвэрлэсэн.<br>4. 7 хоног бүрийн 5 өдөр албаны тайланг гарган авч танилцсан.<br>5. 7 хоног бүрийн 5 өдөр ЗУГ-т 7 хоногийн ажлын төлөвлөгөөг гарган хугацаанд нь хүргүүлсэн<br>6. Edoc.ecustoms.mn программаар 55 албан бичиг ирснийг шийдвэрлэсэн.<br>7. 7 хоног бүрийн 4 өдөр Сангийн сайдын үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.<br>8. СЭГГ-т 3 хоног, ЗҮГГ-т 3 хоног тус тус томилолтоор удирдлагын өгсөн үүрэг даалгаврын дагуу ажилласан.<br>9. Өдөр тутамд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хугацаанд нь биелүүлэн ажилласан.<br>10. Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны группын ажиллах дүрмийн төслийг боловсруулж, ЗББНДБ, ГГХ-оос саналыг авч нэгтгэсэн.<br>11. ОНХА-ны журмын төслийг боловсруулж, ЗББНДБ, ГГХ-оос саналыг авч журмыг мэргэжлийн зөвлөлийн хурлаар оруулахаар бэлтгэж байна. | 2024.01.01<br>-<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
